

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Сарын тойм: 2014 оны 1 дүгээр сар

МХБ-ийн ТОП-20 Индекс, сүүлийн нэг жилийн үзүүлэлт

16,046.31 (-11.5% өмнөх оны мөн үетэй харьцуулсан өөрчлөлт)



МХБ Топ-20 багцад багтах хувьцаа

(Хувьцааны үнэ, сарын үзүүлэлт 2014 оны 1-р сарын 9-ний өдрөөр)

Силикат ХК (SIL)	250	+25.0%
Баянгол зочид буудал ХК (BNG)	59,000	+18.0%
Улсын их дэлгүүр ХК (UID)	540	+12.3%
Монголын цахилгаан холбоо ХК (MCH)	1,375	+11.8%
Говь ХК (GOV)	5,600	+10.5%
Багануур ХК (BAN)	4,800	+8.9%
Шарын гол ХК (SHG)	7,700	+8.3%
Шинвээ овоо ХК (SHV)	7,500	+7.1%
Могойн гол ХК (BDL)	16,670	+5.6%
Монголиа девелопмент ресорсес ХК (MDR)	699.98	+4.8%
Сүү ХК (SUU)	89,520	+4.1%
АПУ ХК (APU)	4,100	+3.8%
Улаанбаатар зочид буудал ХК (ULN)	93,040	+3.4%
Би ди сек ХК (BDS)	2,400	-0.2%
Монгол шилтгээн ХК (MSH)	970	-0.7%
Таван толгой ХК (TTL)	5,500	-2.0%
Хөх ган ХК (HGN)	127.2	-2.2%
Женко тур бюро ХК (JTB)	88	-2.2%
Ремикон ХК (RMC)	158.50	-6.2%
Талх чихэр ХК (TCK)	14,000	-6.3%

Эх сурвалж: МХБ

Олон улсын индексүүд

Индекс	Өмнөх оны мөн үетэй харьцуулсан өөрчлөлт	2014.01.01-тэй харьцуулсан
DJIA (US)	+25.99%	-0.62%
Nikkei 225 (JP)	+59.28%	-2.52%
Hang Seng (HK)	+2.27%	-1.65%
DAX 30 (DE)	+23.02%	-0.57%
SMI (CH)	+19.47%	+1.83%
MSE 20	-11.5%	-1.27%

Эх сурвалж: Блүүмберг

Валютын ханш

Валютын ханш	2014.1.08	Өмнөх сарын мөн үетэй харьцуулсан өөрчлөлт
USD - ТӨГ	1,722	-0.07%
JPY - ТӨГ	16.40	-2.79%
EUR - ТӨГ	2,345.94	-0.34%
CHF - ТӨГ	1,894.16	-1.34%

Эх сурвалж: Монголбанк

ШИНЭ ОНОО ШИНЭ ХУВЬЦААТАЙ ЭХЭЛЖ БАЙНА

Стандарт Инвестмент ХХК нь Монголын хөрөнгийн бирж дээр арилжигдах нэгэн шинэ хувьцааг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэх ажиллагааг амжилттай гүйцэтгэж, 2014 онд МХБ дээр Мерекс гэдэг шинэ хувьцаа гаргах боллоо. СЗХ-ны 12-р сарын 18-ны өдрийн ээлжит хуралдаанаар Мерекс ХХК-ийн нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх хүсэлтийг хэлэлцэж, 514 дүгээр тогтоолоор баталснаар ийнхүү Мерекс ХХК нь үйл ажиллагаагаа банкны зээлээр бус хөрөнгийн зах зээл дээрээс хөрөнгө босгон санхүүжүүлэх боломжтой болов.

Мерекс ХК нь цагт 150м³ бетон зуурмаг үйлдвэрлэх хүчин чадалтай бетон зуурмагийн үйлдвэрийг Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт шинээр барьж суурьлуулсан бөгөөд 2014 оны хавраас ашиглалтанд оруулах юм. Компанийн үүсгэн байгуулагчид нь нийт хөрөнгийн 60 хувийг бүрдүүлж, бетон зуурмагийн үйлдвэр, үйлдвэрийн газар, тусгай зориулалтын техник хэрэгсэлд хөрөнгө оруулсан ба үлдсэн 40 хувийг буюу 2.6 тэрбум төгрөгийг нэгж бүр нь 100 төгрөгийн үнэтэй 26 сая энгийн хувьцааг МХБ-ээр дамжуулан нийтэд худалдаж, олон нийтээс татан төвлөрүүлэх юм. Стандарт Инвестмент ХХК нь Мерекс ХК-ийн энэхүү IPO-г 2014 оны 2-р сард багтаан хийхээр төлөвлөж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг www.standardinvestment.mn-ээс эсвэл компанийн байранд ирж авна уу.

2014 оны төлөв байдал

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын эдийн засгийн өсөлт уул уурхайн бүтээгдэхүүний экспорттой шууд уялдаж ирсэн. 2013 онд манай улсын нийт экспортын хэмжээ 5 хувиар буурсан хэдий ч Оюу Толгойн зэсийн баяжмалын экспорт эхэлсэн түүнчлэн Шинхуа-тай хийсэн нүүрс экспортлох гэрээ амжилттай хийгдсэн тул 2014 онд нийт экспортын хэмжээ эргэн өсөх төлөвтэй байна. 2014 оны зарим экспортын төлөвлөгөө дараах байдалтай байна. Үүнд:

- Оюу Толгой ХХК нь 2014 онд 175 мян.тн зэсийн баяжмал, 771 мян.унци алт олборлон, нийт 2.6 сая долларын борлуулалт хийхээр төлөвлөсөн байна.
- Эрдэнэс Тавантолгой ХК нь Баруун Цанхийн уурхайгаас 2.5 сая тонн нүүрс олборлон, 100 орчим сая долларын борлуулалтын орлого олохоор төлөвлөжээ.

2014 онд манай улс уул уурхай, экспортод анхаарлаа хандуулахаас гадна улсын өрийн хяналтыг сайжруулах, төсвийн алдагдлыг хамгийн доод хэмжээнд барих нь нэн чухал гэдгийг дотоодын болон олон улсын шинжээчид үзэж байна. Ерөнхийдөө эдийн засаг 2014 онд 15% өсөх таамаглал байна.


Сүүлийн жилүүдэд шинээр үнэт цаас гаргасан компаниудын жагсаалт (IPO)

№	Компанийн нэр	Гарсан он	Хувьцааны анхдагч үнэ, төгрөг	Хувьцааны тоо	Зах зээлийн үнэлгээ 2014.01.09
1	Монгол шилтгээн ХК	2005	290	10,000,000	9,700,000,000
2	Женко тур бюро ХК	2006	100	100,000,000	8,800,000,000
3	БиДиСек ХК	2006, 2008	100	11,000,000	26,400,000,000
4	ХайБиОйл ХК	2007, 2007, 2010	100	9,234,268	3,139,651,120
5	Оллоо ХК	2007	100	9,700,497	1,319,267,592
6	Гермес ХК	2008	100	78,543,001	12,906,971,354
7	Ремикон ХК	2008	100	78,679,464	12,470,695,044
8	Нако түлш ХК	2008, 2010	100	12,615,721	2,636,685,689
9	Хөх ган ХК	2008	100	101,317,557	12,887,593,250
10	Э-транс ложистик ХК	2012	120	46,200,000	5,220,600,000

Эх сурвалж: МХБ


Стандарт Инвестмент ХХК-аас энэ сард санал болгож буй багц

Хөрөнгө оруулалтын багц



Хөрөнгө оруулалтын багц нь урт хугацааны хөрөнгө оруулагчид тохиромжтой.

Арилжааны багц



Арилжааны багц нь дунд болон богино хугацааны өгөөж эрэлхийлж байгаа хөрөнгө оруулагчид тохиромжтой.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дараах и-мэйл болон утсаар холбогдоно уу.

chimgee@standardinvestment.com

70114433

Холбоо барих хаяг

Стандарт Инвестмент ХХК
Жигжиджавын гудамж 5/3
1-р хороо, Чингэлтэй дүүрэг Улаанбаатар хот

Шуудангийн хаяг:
Шуудангийн хайрцаг 1487 Төв шуудан
Улаанбаатар - 15160

Утас: 70114433
info@standardinvestment.mn
www.standardinvestment.mn

Тодруулга болон мэдэгдэл

Энэхүү тойм мэдээг Стандарт Инвестмент ХХК бэлтгэсэн болно. Тойм мэдээнд дурьдагдсан хувьцаат компаниуд болон тэдгээрийн хувьцааны талаарх мэдээлэл, дүгнэлтийг үнэн зөвөөр гаргахыг хичээсэн бөгөөд Стандарт Инвестмент ХХК-ийн шинжээчдийн өөрсдийн үзэл бодол болно.

Стандарт Инвестмент ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооноос андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх, брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, Монголын хөрөнгийн биржийн гишүүн байгууллага юм. Бид иргэд, байгууллагуудад үнэт цаас худалдах, худалдан авахад нь зуучлах, өөрийн нэр дээр үнэт цаас худалдан авах, худалдах, хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон үйлчилгээ үзүүлэх, андеррайтер болон хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээ үзүүлдэг.

ЭНЭХҮҮ ТОЙМ МЭДЭЭ НЬ ЯМАР НЭГЭН ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ, ХУДАЛДАХ САНАЛ БИШ ЮМ. ЭНД ДУРДСАН ҮНЭ ХАНШИЙН МЭДЭЭ, БУСАД ТООН МЭДЭЭЛЭЛ, ТАЙЛБАР ЗЭРЭГ НЬ ЗӨВХӨН ТУХАЙН МЭДЭЭЛЛИЙГ БЭЛТГЭХ ҮЕИЙН БАЙДЛЫГ ИЛТГЭХ БӨГӨӨД ӨӨРЧЛӨГДӨЖ, ХУВЬСАЖ БОЛНО /СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ХХК ӨӨРЧЛӨЛТИЙГ МЭДЭГДЭХ АЛБАГҮЙ/. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ЭРСДЛИЙГ ӨӨРӨӨ ХАРИУЦНА.

ЭНЭХҮҮ ТОЙМ МЭДЭЭНИЙ БҮХ МЭДЭЭЛЛИЙГ ЗӨВХӨН МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ ЗОРИЛГООР БЭЛДСЭН БӨГӨӨД НАЙДВАРТАЙ, САЙН САНААНЫ ҮҮДНЭЭС ГАРГАСАН ГЭЖ ҮЗСЭН ЭХ СУРВАЛЖААС АВЧ БОЛОВСРУУЛСАН ХЭДИЙ Ч МЭДЭЭЛЭЛ ТУС БҮРИЙГ НЭГБҮРЧЛЭН ХЯНАЖ ШАЛГААГҮЙ БОЛНО. ТИЙМЭЭС СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ХХК НЬ ЭДГЭЭР МЭДЭЭЛЛИЙН ҮНЭН ЗӨВ, БОДИТ БӨГӨӨД БҮРЭН БҮТЭН БАЙДАЛД БАТАЛГАА ГАРГАХГҮЙ БӨГӨӨД МЭДЭЭЛЛИЙГ ДАМЖУУЛАХААС ҮҮССЭН АЛИВАА АЛДААГ ХАРИУЦАХГҮЙ. ТҮҮНЧЛЭН, ЭНЭХҮҮ ТАЙЛАНГ АШИГЛАСНААС УЧИРСАН АЛИВАА ХОХИРОЛД СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ХХК ЯМАР НЭГЭН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХГҮЙ.

ЭНЭХҮҮ ТОЙМ БОЛОН СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ХХК-ИЙН АЛИВАА МЭДЭЭЛЛИЙГ ЯМАР НЭГЭН ХЭЛБЭРЭЭР ЦААШ НЬ ДАМЖУУЛАХ, ТҮГЭЭХ, ХУУЛБАРЛАХЫГ ХОРИГЛОНО.